

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны ... сарын
... өдөр

Дугаар ...

Төрийн ордон, Улаанбаатар хот

ОНЦГОЙ ДЭГЛЭМИЙН ХУГАЦААГ СУНГАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1, 93.2 дахь хэсэг, БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нүүрсийг биржээр дамжуулан хил нөхцөлөөр борлуулах үйл ажиллагааг тогтворжуулах, гадаад валютын орох урсгал, нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасугай.

2.“Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан асуудлын хүрээнд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, онцгой дэглэм, түүний хэрэгжилтийн явцыг танилцуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Т.Энхтүвшин/-нд үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолыг 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ